



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

2020-2021 оны хичээлийн шинэ жил

Мандах Их Сургууль 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн нээлтээ 2020 оны 8-р сарын 31-ний өдөр онлайнаар амжилттай зохион байгууллаа. Хичээлийн шинэ жилийг нээж сургуулийн захирал профессор Г.Нанжид үг хэллээ. Тэрээр, манай хамт олон өнгөрсөн хичээлийн жилд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд хэд хэдэн хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн бөгөөд цар тахлын үед сургалтын үйл ажиллагаагаа тасалдуулалгүй онлайнаар амжилттай зохион байгуулж чадсан хамт олондоо талархал илэрхийллээ. Мөн шинэ хичээлийн жилийн эхний өдөр Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрчилгээг хүлээн авч, Монгол улсад анх удаа энэхүү стандартыг хэрэгжүүлсэн байгууллага болж байгааг онцлон тэмдэглэлээ.



ББМТ-ны ISO 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэгч анхны боловсролын байгууллага боллоо



CERTIFICATE OF APPROVAL

Issued by Indian Register Quality Systems
(A Division of IRCLASS Systems and Solutions Private Limited)

This is to certify that the Educational Organizations Management Systems of

Organisation: Mandakh University

Address: Bayangol district, 16th Khoroo,
Amarsanaa Street 18/1, Ulaanbaatar,
Mongolia

has been assessed and found conforming to the following requirement

Standard: ISO 21001:2018

Scope: Design, Development and Conducting
Educational Programs - Under Graduate
and Graduate

Certificate No. : IRQS/203100375

Original Certification Date: 30/07/2020

Current Date of Granting: 30/07/2020

Expiry Date: 29/07/2023



Shashi Nath Mishra
Head IRQS

Эрдэм шинжилгээ, судалгаа

"Зөв сэтгэлгээ-Зөв хөгжил" Оюутны эрдэм шинжилгээний хуралд дэд байранд шалгарлаа

Монголын ногоон уламжлал сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Ногоон уламжлалаа хамтдаа хөгжүүлэе" аяны хүрээнд "Зөв сэтгэлгээ-Зөв хөгжил" оюутны эрдэм шинжилгээний 15 дах удаагийн хурал 2020.10.31-ны өдөр Тусгаар тогтнолын ордонд амжилттай болж өндөрлөлөө. Монголчуудын түүхэн уламжлал, өв соёл, байгаль экологио хайрлан хамгаалах, түүнд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, боловсролыг дэмжих зорилгоор зохиогддог "Ногоон уламжлал" аяны гол чухал ажлын нэг нь оюутны ЭШХ юм. Тус хуралд МУИС, МУБИС, ШУТИС, МАНДАХ, ШИХИХУТУГ, ИДЭР, ИЗОУИС сургуулиудын 24 илтгэгчид мэдлэг оюун, илтгэх урлаг, ухаанаа уралдуулан оролцсон болно.

Тус оюутны ЭШХ-д НББ-ийн тэнхимийн ахлах багш А.Наранцэцэг (Ph.D)-ийн удирдсан нягтлан бодох бүртгэлийн 3-р курсын оюутан Б.Баянжаргал, Э.Тэгшжаргал нарын "Нийгмийн үе, хүйс болон сэтгэлгээний оюун ухааны ялгаатай байдлын судалгаа" илтгэл 2-р байранд шалгарч, батламж, 200.000 мянган төгрөг, дурсгалын зүйл, маршрутын дагуу Улаанбаатар хотын 1 өдрийн 100 000₮-ийн аялал /2 хүн/-ын эзэд болов.



Эрдэм шинжилгээ, судалгаа

Тэнхимүүдийн оюутны эрдэм шинжилгээний хурал цахимаар амжилттай зохион байгуулагдлаа

Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хөгжүүлэх, багш, оюутны хамтарсан судалгааг дэмжих зорилготойгоор Нягтлан бодох бүртгэлийн тэнхим, Гадаад хэлний тэнхим, Эдийн засаг бизнесийн тэнхимээс “ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ”-ыг 2020.11.26 болон 27-ны өдрүүдэд цахимаар зохион байгууллаа. Тус хуралд нийт 40 орчим бүтээл ирснийг хэлэлцүүлж, тэнхим бүр шилдэг илтгэлүүдээ шалгаруулсан байна. Үүнд:

	ОЮУТНЫ НЭР	АНГИ	ИЛТГЭЛИЙН СЭДЭВ	ЭЗЭЛСЭН БАЙР	ТЭНХИМ
1	Г.Энх-Отгон	НББ Статистик-4	Компанийн хувьцааны үнэ ба хүрээлэн буй орчны үзүүлэлт хоорондын хамаарлын мета анализт системт тойм судалгаа	I	НББТ
2	Г.Мягмарсүрэн	НББ Статистик-4	Гүйцэтгэлийг хэмжих түлхүүр үзүүлэлтийн асуулгын хүчин төгөлдөр байдлыг үнэлсэн судалгаа	II	
3	Б.Алтанзул	НББ Статистик-4	Хувьцаат компаниудын ашгийн удирдлагын харьцуулсан судалгаа	III	
4	Н.Дэлгэрмагнай	НББ Аудит-3	Бизнесийн байгууллагын санхүүжилтийг үнэлэх нь	Тусгай байр	
5	Г.Энхжин Б.Гүнсэнхорол А.Буяндэлгэр	НББ Статистик-3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дээд боловсролын боломжийн судалгаа	I	ГХТ
6	Б.Ганцэцэг	НББ Англи хэл-4	Монгол ардын “Үлэмжийн чанар” дууг үндэсний сэтгэлгээний онцлог, гүн ухааны үүднээс судлах нь	II	
7	Х.Гүлнур	Санхүүгийн менежмент-3	Даатгалын бүтээгдэхүүнийг сонгоход нөлөөлөх хүчин зүйлс ба сэтгэлзүйн нөлөө	III	
8	Э.Эрдэнэбилэг Н.Оролмаа	НББ Англи хэл-4	Их дээд сургуулийн оюутнуудын чанаргүй боловсрол эзэмшихэд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа	Тусгай байр	ЭЗБТ
9	Э.Бат-Оргил Ц.Сарангуа Б.Бат-Эрдэнэ	НББ Банк-4	Гүн сургалтын аргаар алдааг агуулсан санхүүгийн тайланг илрүүлэгч FRAUD загвар боловсруулах нь	I	
10	Э.Бат-Оргил	НББ Банк-4	Зээлдэгчийн зээлжих чадварыг машин сургалтын зарим аргуудаар үнэлэх нь	II	
11	Ц.Сарангуа	НББ Банк-4	Монгол улсын эдийн засгийн өсөлт ба банкны зээлийн сүвгийн хамаарлыг үнэлэх нь	III	
12	Х.Гүлнур	Санхүүгийн менежмент-3	Ковид-19 цар тахлын Монгол улсын валютын ханшид нөлөөлөх нь	Тусгай байр	
13	Б.Лхагвасүрэн	Санхүү Банк-4	Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл	Тусгай байр	

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон Мандах их сургуулийн хооронд Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа

Мандах их сургууль нь 2017 онд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын шаардлага, шалгууруудыг ханган, хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү туршлага дээрээ тулгуурлан, Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг Монгол улсын боловсролын байгууллагуудаас анх удаа хэрэгжүүлж, гэрчилгээгээ 2020 оны 9-р сард хүлээн авсан юм. Тус стандартын үндсэн зарчмуудын нэг нь боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх, суралцагсдын хэрэгцээ шаардлага, хүлээлтэд нийцсэн сургалтын үйл ажиллагаа тэр дундаа тусгай хэрэгцээт суралцагсад бусдын адил боловсрол эзэмших боломж олгох явдал байдаг. Мандах их сургууль энэхүү боломжийг бий болгосон тул Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тус их сургуулийг сонгон авч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дэмжих, тэднийг нийгэмшүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хамтран ажиллахаар болсон юм.

Ийнхүү Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Мандах их сургуулийн хооронд байгуулсан санамж бичигт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд А. Ариунзаяа, Мандах их сургуулийн захирал Г. Нанжид нар 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурав. Санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллах юм. Үүнд:

Боловсролын байгууллагуудыг манлайлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй “Загвар их сургууль” болоход чиглэсэн арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд тус сургуульд суралцаж, дээд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэдийг чадавхжуулах, эдийн засаг, санхүү, бизнесийн боловсрол олгох сургалт зохион байгуулах

Хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажилд оюутан суралцагсад, багш, ажилтнуудыг хамруулан зохион байгуулах зэргээр хамтран ажиллах боллоо.



Дотоод хамтын ажиллагаа

Хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурлаа

Мандах их сургууль нь Монголтакс ТМЗ ХХК-тай 12 жилийн турш хамтран ажиллаж ирсэн бөгөөд энэ хугацаанд тус байгууллагатай “Өртгийн удирдлага ба зардлын бүртгэл” сэдэвт олимпиадыг жил бүр хамтран зохион байгуулж, тэргүүн байранд шалгарсан оюутнуудыг “Цалинтай дадлага” хөтөлбөрт хамруулж ирснээс нийт 31 оюутан энэхүү хөтөлбөрт хамрагдсан байна.

Түүнчлэн Мандах их сургуулийн 100 гаруй оюутан Монголтакс ТМЗ ХХК-д үйлдвэрлэлийн дадлагаа хийж, олж авсан онолын мэдлэгээ практик дадлагатай хослуулж, мэргэжлийн чиг баримжаа, ойлголтоо дээшлүүлсэн байна.

2020-2021 оны хичээлийн жилд хоёр байгууллага хамтын ажиллагаагаа өргөжүүлж, үе шаттайгаар хөгжүүлэх зорилгоор дахин шинээр “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдөр байгуулж, гарын үсэг зурж, баталгаажууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд өмнө нь хэрэгжүүлж байсан “Өртгийн удирдлага ба зардлын бүртгэл” сэдэвт олимпиадыг онлайн хэлбэрээр зохион байгуулахын зэрэгцээ Монголтакс ТМЗ ХХК -ны нэрэмжит “Манлайлагч оюутан” 500,000 төгрөгийн мөнгөн шагналтай тэтгэлэгт хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэхээр боллоо. Мөн түүнчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх” чиглэлээр санал санаачилга боловсруулан, энэ хүрээнд өрх гэр бүл, бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчид зэрэг нийгмийн тодорхой бүлгүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах юм.



Дотоод хамтын ажиллагаа

Хамтын ажиллагааны гэрээ байгууллаа

2020 оны 10-р сарын 19, 20-ны өдөр Малчдын байгууллагын хоорондын бизнес хөгжлийн сургалтын үеэр Мандах Их Сургууль, Тогтвортой ноос ноолуурын эвсэлтэй хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Энэхүү хоёр байгууллагын хамтын ажиллагаа нь ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага /хоршоод/-ын засаглалыг бэхжүүлж, чадавхийг дээшлүүлэхэд, чиглэгдсэн дараах ажлуудыг тусгалаа. Хоршоодын түүхий эд худалдаа, бэлтгэлд чанарын тогтолцоог нэвтрүүлэх, хоршоодын удирдлага, гишүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон хоршоодын бүртгэл тооцоог сайжруулахад чиглэгдсэн сургалт зохион байгуулах, сургалтад хамрагдсан оролцогчдын мэдлэг чадварыг үнэлэн, батламж олгох, хамтарсан хурал семинар зохион байгуулан, туршлагаа хуваалцах, судалгаа, шинжилгээний ажил хамтран явуулах, бэлтгэн нийлүүлэгч малчдад зориулсан сургалт семинар, уулзалт болон хоршоодын онцлогт тохирсон бусад олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх юм.



Хүрэлтогоот 2020 ЭШХуралд тэргүүлээ

БШУЯ, МЗЭХ, ШУА, ШУТС, Их дээд сургуулиуд хамтран зохион байгуулдаг #Хүрэлтогоот_2020_ЭШХ энэ жил 17 дахь удаагаа 2020 оны 12-р сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдлаа. Анагаах ухаан, Инженерчлэл технологи зэрэг шинжлэх ухааны 7 салбарын 80 гаруй шилдэг бүтээл сүүлийн шатанд хэлэлцүүлж #БШУЯ-ны_сайдын_нэрэмжит 4 сая төгрөгийн 2 грант болон 1 тусгай байрыг тус бүр шалгаруулсан байна. Эдийн засаг бизнесийн салбар хуралдаанд МУИС, ХААИС, ШУТИС, СЭЗИС зэрэг их, дээд сургуулиуд болон эдийн засгийн хүрээлэн зэрэг байгууллагуудын багш, судлаачид оролцлоо. Мөн БШУЯ-аас томилсон шүүгч МУИС-ийн БС-ийн захирал Ч.Энхбаяр, ШУТИС-ийн багш Л.Оюунцэцэг, СЭЗИС-ийн багш Ч.Наранчимэг, Тээвэр хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбаяр, БШУЯ-ны Б.Атарцэцэг нараас гадна хөндлөнгийн шүүгчид, ажиглагчид, зохион байгуулагчид зэрэг олон байгууллагын төлөөлөл ажилласан байна.

Ингээд эдийн засаг, бизнесийн удирдлагын салбар хуралдааны шагналт байруудаар:

Тэргүүн байрын грантыг Мандах ИС-ийн ахлах багш С.Мөнхцэцэг, багш Ж.Гантулга нарын “Скоринг болон машин сургалтын зарим аргад тулгуурлан зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоох нь” сэдэвт илтгэл.

Дэд байрын грантыг Мандах ИС-ийн төгсөгч А.Наранхуягийн “Хөрөнгө оруулагчдын зан төлөвийн төөрөгдөлийг үнэлэх нь” сэдэвт илтгэл.

Тусгай байрт

Мандах ИС-ийн багш Г.Эрдэнэцогт, Г.Уянга нарын “Уул уурхайн бус салбарын экспорт дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөлөл” сэдэвт илтгэл тус бүр шалгарч нэр хүнд бүхий грантын эзэд боллоо.



Үйл явдлууд

ББМТ-ны ISO 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэгч анхны боловсролын байгууллага боллоо

Мандах их сургууль нь 2017 онд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын шаардлага, шалгууруудыг ханган, хэрэгжүүлсэн байгууллага болж, гэрчилгээгээ хүлээн авсан билээ. Уг стандартыг хэрэгжүүлснээр байгууллагын дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, стандартын үндсэн зарчмын дагуу төлөвлөх, гүйцэтгэх, хянах, сайжруулалт хийх үйл явц тогтмолжиж, байгууллагын үйл ажиллагааны үр дүн байнга дээшлэхэд ач холбогдолтой боллоо.

Энэхүү стандартыг өөрийн сургууль дээр амжилттай хэрэгжүүлсэн туршлага дээрээ тулгуурлан, Мандах их сургууль Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэх зорилт тавин, Олон улсын баталгаажуулалтын IRCLASS байгууллагатай хамтран ажилласны үр дүнд өнөөдөр тус стандартыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрчилгээг хүлээн авлаа.

Энэхүү стандартын үндсэн зорилго нь суралцагсдын хэрэгцээ шаардлага болон хүлээж буй үр дүнд нийцүүлсэн дээд боловсролын үйлчилгээг чанартай үзүүлэхэд чиглэгддэг.

Ийнхүү Мандах их сургууль Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлсэн анхны боловсролын байгууллага боллоо.



Хүмүүнлэгийн аян зохион байгууллаа

Мандах Их сургууль ISO21001:2018 боловсролын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч хамт олон бөгөөд энэхүү ажлын хүрээнд Нийгэм, тогтвортой хөгжлийн багийг шинээр байгуулан ажиллаж байна.

Тухайн байгууллагын тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нийгмийн хариуцлага гэж үздэг. Өөрөөр хэлбэл, татвараа цаг хугацаанд нь төлөх, ажлын байран дахь цахилгаан, дулаанаа хэмнэдэг, ажилчдаа эрүүл мэндийн даатгалд хамруулдаг, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хог хаягдлын хэмжээгээ бууруулдаг байх зэрэг юм.

Энэ хичээлийн жилд Нийгэм, тогтвортой хөгжлийн багаас нийгмийн хариуцлагын нэг хэлбэр болон хэрэгждэг хандив, тусламж нь хүрч буй хүмүүсдээ өгөөжтэй байхыг чухалчлан үзэн, ажлын төлөвлөгөөгөө нийгмийн эмзэг бүлэгт туслах, байгаль орчныг хамгаалах үйлсэд илүүтэй чиглүүлсэн юм.

Энэхүү ажлын нэг хэсэг болох нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст туслах аянаар өөрийн сургууль байрладаг БГД-ийн 16-р хорооны судалгаанд үндэслэн хагас өнчин 2 хүүхдэд тусаллаа.



Үйл явдлууд

Мандах Их Сургуулийн захиргаанаас оюутны байранд амьдарч буй оюутнууддаа хоол хүнсний дэмжлэг үзүүллээ

Мандах Их Сургуулийн захиргаанаас оюутны байранд амьдарч байгаа оюутнууддаа хүнс болон дархлаа дэмжих бүтээгдэхүүний багц /гурил, мах, гоймон, төмс, лууван, байцаа, боорцог, чацарганы өтгөрүүлсэн жүүс, витамин С/ -аар дэмжлэг үзүүллээ. Оюутны байрны интернетийн үйлчилгээг сайжруулан интернетийг хурдны хязгааргүй болгож сургуулийн цахим сургалт болон LIVE хичээлд саадгүй хамрагдах бололцоог хангалаа.

Түүнчлэн оюутны байрны оюутнуудад халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг зөвлөж гар ариутгагч, маск, бээлий, ариун цэврийн цаас, ариутгал цэвэрлэгээний бодисыг өглөө.





Үйл явдлууд

Ажлын байрны цахим өдөрлөг боллоо

2020 оны 12 сарын 10-ны өдөр Мандах Их Сургуулийн дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”, маркетингийн багтай хамтран уламжлалт “Ажлын байрны өдөрлөгийг цахимаар амжилттай зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгийн зорилго нь ажил олгогчдод боловсон хүчний нөөцийг бүрдүүлэхэд туслах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Мандах Их сургуулийн оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, төгсөгчдийг ажлын байранд зуучлахад дэмжлэг үзүүлэх юм.

Өдөрлөгийн үйл ажиллагааг нээж Сургалт эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор Ч.Төрбадрах хамтрын ажиллагаатай аж ахуйн нэгж болон оюутнууддаа хандан үг хэллээ. Төгсөх ангийн оюутнуудад зориулан Монголын хүний нөөцийн институтийн захирал Д.Бартанбаатар /Төгсөгчдийн холбооны сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд ерөнхийлөгч/ “Ажлын байрны ярилцлагад бэлтгэх, карьер төлөвлөлт болон хүний нөөцийн асуудал” сэдэвт сургалт хийж, оюутнуудын сонирхсон асуултад хариулж, харилцан яриа өрнүүллээ. Өдөрлөгт 20 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцож, 60 гаруй ажлын байрны захиалга өгсөн байна.




Үйл явдлууд

Шинэ жилийн баяраа цахимаар тэмдэглэлээ

Мандах Их Сургуулийн багш, ажилтан нарын шинэ жилийн баярын арга хэмжээ 2020 оны 12-р сарын 30-ны өдөр цахимаар болж 2020 оны шилдгүүдээ тодрууллаа.

Цахим үйл ажиллагааг нээж захирал профессор Г. Нанжид үг хэллээ.

Тэрээр 2020 онд дэлхий нийтэд тархсан цар тахлын хөл хорионы энэ хүнд нөхцөлд бүхий л үйл ажиллагааг тасалдуулалгүй амжилттай зохион байгуулж, улсын хэмжээний ЭШХ, уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцсон багш, ажилтнууддаа халуун баяр хүргээд, ирж буй шинэ ондоо амжилтаа улам бататган, эрүүл энх аз жаргалаар дүүрэн байхыг хүсэн ерөөлөө.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалт эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

С.Булганаа / Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Номын санч/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn